

1.4. Шинэ өрөө үүсгэх

1.4. Шинэ өрөө үүсгэх

Энэхүү үйлдлийг сургалтын үйл ажиллагаа явуулахад ашиглаж байгаа байрыг систем дээр үүсгэсний дараа түүнд байрлах өрөө бүрийг шинээр үүсгэхэд ашиглана.

Шинэ өрөө үүсгэхээс өмнө системд дараах үйлдлийг хийсэн байх ёстой.

Бүртгэх гэж буй өрөө байрлах **байрыг** БУС-ийн сургалтын орчин үйл ажиллагааны байр таб-д шинэ байр үйлдлээр бүртгэсэн байх. (нэмэлт зориулалтаар ашигладаг байрны өрөө, танхимыг бүртгэхээс өмнө тухайн бүртгэсэн байрны нэмэлт зориулалт хэсэгт уг байрыг бүртгэж өгсөн байх)

Шинэ өрөө үүсгэх үйлдлийг хийхэд дараах дарааллыг баримтална. Үүнд:

БУ системийн Сургалтын орчин үйл ажиллагааг сонгоно.

1.**Шинэ өрөө** үйлдлийг дарна.

2.**Шинэ өрөө** бүртгэлийн цонхны мэдээллийг оруулж хадгална.

Үйл ажиллагааны жагсаалтаас **Сургалтын орчин**-г сонгоход дараах цонх нээгдэнэ.

Баруун дээд хэсэгт байрлах **Шинэ өрөө** гэсэн үйлдлийг дарахад дараах бүртгэлийн цонх нээгдэнэ.

| № | Байр | Тоот | Өрөөний нэр | Төрөл | Багтаамж | Эд хөрөнгө |
|----|------|------|--------------------------|------------------------|----------|---|
| 1 | Б3 | 113 | Нийгмийн ажилтны өрөө | Нийгмийн ажилтны өрөө | 2 | Компьютер(2),Принтер(2),Сандал(5),Сканне... |
| 2 | Б3 | 217 | Багш нарын өрөө | Багшийн өрөө | 20 | Богино долгионы зуух(1),Дэлгэц(1),Номын та... |
| 3 | Б3 | 217а | Сургалтын менежер1 | Бусад ажилтны өрөө | 1 | Ангийн самбар(1),Багшийн сандал(1),Багший... |
| 4 | Б3 | 217б | Сургалтын менежерийн ... | Бусад ажилтны өрөө | 1 | Ангийн самбар(2),Багшийн ширээ (1),Дэлгэц(... |
| 5 | Б3 | 00 | Ариун цэврийн өрөө | Ариун цэврийн өрөө/00/ | 5 | Суултуур(5),Угаалтуур(5),Хогийн сав(5) |
| 6 | Б3 | 219 | Гүйцэтгэх захирал | Захирлын өрөө | 1 | Ангийн самбар(1),Бусад цахилгаан хэрэгсэл(... |
| 7 | А2 | 220 | Багшийн хөгжлийн өрөө | Бусад ажилтны өрөө | 11 | Ангийн самбар(1),Багшийн ширээ (1),Компью... |
| 8 | Б3 | 218 | Номын сан | Номын сан | 20 | Ангийн самбар(2),Компьютер(1),Номын тави... |
| 9 | Б3 | 118 | Няравын өрөө | Бусад ажилтны өрөө | 5 | Компьютер(1),Принтер(1),Сандал(1),Ширээ(1) |
| 10 | Б3 | 108 | Хичээлийн танхим | Хичээлийн танхим | 40 | Ангийн самбар(2),Багшийн сандал(1),Багший... |

БОЛОВСРОЛЫН УДИРДЛАГА

Анги, танхим засах: Хими-1

Хадгалаад хаах

Байр: Хичээлийн 1-р байр
 Байрны зориулалт: Хичээлийн байр
 Анги, танхимын нэр: Хими-1
 Төрөл: Хичээлийн танхим
 Танхимын төрөл: Хими
 Байрлах давхар: 203
 Тоот: 2
 Багтаамж (хүнээр): 35
 Өндөр (м): 2.5

Урт (м): 5
 Өргөн (м): 2.8
 Давхцал шалгах эсэх:
 Гэрчилгээтэй эсэх:
 Гэрчилгээний дугаар: 0152002026
 Олгосон огноо: 2015-09-19
 Дуусах огноо: 2017-09-19
 Бүрэлдэхүүнтэй эсэх:

Бүрэлдэхүүн өрөө

| Өрөө | Төрөл | Багтаамж |
|------------------|-------------------|----------|
| химийн арын өрөө | Химийн лаборатори | 6 |

Эд хөрөнгө

| Нэр | Тоо ширхэг |
|------------------|------------|
| Сурагчийн сандал | 35 |
| Сурагчийн ширээ | 35 |
| Ангийн самбар | 1 |
| Багшийн ширээ | 1 |
| Багшийн сандал | 1 |

Ашиглах боломжгүй цаг

| Гарар | Эхлэх цаг | Дуусах цаг |
|-------|-----------|------------|
|-------|-----------|------------|

•Байр

Бүртгэх өрөө байрлаж байгаа байрыг сонгоно. Жич: Хичээлийн 1-р байр.. (Хичээлийн 1-р байранд байрлаж байгаа өрөөг бүртгэх бол)

•Байрны зориулалт

Өрөө байрлаж байгаа байрны зориулалтыг сонгож өгнө. Жич: Хичээлийн байр

•Өрөөний нэр

Тухайн өрөөний нэрийг бичнэ. Жич: Математик-1

•Төрөл

Өрөөний төрлийг зөв сонгож өгнө. Өрөөний төрлийн сонголтоос хамаарч дараагийн бүртгэлийн талбарууд өөрчлөгдөнө. Хэрэв та хичээлийн **анги, танхим** өрөөг бүртгэх гэж байгаа бол **хичээлийн танхим** сонголтыг сонгож өгснөөр дараагийн бүртгэх талбарт хичээлийн танхимын төрлийг сонгох боломжтой болно. Жич: Хичээлийн танхим, биеийн тамирын заал...

•Танхимын төрөл

Төрөл талбарт **хичээлийн танхим** сонголт хийсэн бол энэхүү талбар гарах бөгөөд анги, танхимын жагсаалтаас бүртгэх **танхимын төрлийг** зөв сонгоно. Жич: Математик (энэ нь математикийн анги, танхим гэсэн үг юм.)

•Байрлах давхар

Өрөөний байрлаж байгаа давхрыг бичнэ. Жич: 2

• Тоот

Өрөөний дугаар тоотыг бичнэ. Жич: 203

•**Багтаамж (хүнээр)**

Өрөө хэдэн хүний багтаамжтайг бичнэ. Жич: 35

•**Өндөр (м)**

Өрөөний өндрийг метрээр бодож **тоо** бичнэ. Бутархай тоо бичих бол “**цэг**”-ээр авна. Жич: 2.8

•**Урт (м)**

Өрөөний уртыг метрээр бодож **тоо** бичнэ. Жич: 6

•**Өргөн (м)**

Өрөөний өргөнийг метрээр бодож **тоо** бичнэ. Жич: 5

• **Давхцал шалгах эсэх**

Давхцалыг шалгах бол тэмдэглэгээ хийнэ. (чеклэнэ) Давхцал шалгахгүй гэвэл тэмдэглэгээ хийхгүй (чеклэхгүй).

•**Гэрчилгээтэй эсэх**